

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**Зуунмод
2020 он**

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

НЭГ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1.1 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- 1.2 Иргэний улсын бүртгэл
- 1.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэл
- 1.4 Бүртгэлийн хяналт
- 1.5 Архивын үйл ажиллагаа
- 1.6 Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах
- 1.7.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

ХОЁР. АЖЛЫН БАЙРНЫ БОЛОН ТӨЛӨВЛӨГӨӨТ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

- 2.1 Сургалтын үйл ажиллагаа
- 2.2 Сурталчилгаа
- 2.3 Вэб баяжилт

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН БУСАД АЖЛУУД

- 3.1 Хэлтсийн мэдээллийн ил тод байдлыг хангах, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан ажлын тайлан
- 3.2 Санхүүгийн үйл ажиллагааны тайлан
- 3.3. Хүний нөөцийн үйл ажиллагааны тайлан
- 3.4. Хэлтэст ирсэн явсан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт
- 3.5. Хууль тогтоомж, байгууллагын үйлчилгээний стандарт, Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангах, мэдээ, тайлан хүргүүлсэн байдал, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах талаар хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.6. Аймаг, орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилласан байдал

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2020 онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр **11807**, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр **15335**, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр **1458** бүртгэлийн үйлчилгээ тус тус үзүүлж, **7337** улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, **9540** архивын лавлагаа, мэдээлэл, хуулбар олгож давхардсан тоогоор **45477** иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

2020 оны 11 дугаар сарын 30-ны байдлаар тус хэлтэс нь улс, орон нутгийн төсөвт нийт **416, 463, 976** төгрөг оруулснаас:

- Үйлчилгээний 219,685,250.07 төгрөгийн орлого оруулсан нь төлөвлөгөөг 109.8%-иар биелүүлсэн байна.
- Тэмдэгтийн хураамжийн орлого 32,923,047 төгрөг,
- Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны 2%-ийн татвар 159,649,441 төгрөг,
- Хүү, торгуулийн орлого 8,970,000 төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

1.1 ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР :

2020 онд иргэн, хуулийн этгээдээс нийт 15520 мэдүүлэг хүлээж авснаас 15335 мэдүүлгийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд боловсруулж бүртгэл хийн нотлох баримтыг архивт шилжүүлсэн. Үүнээс 10281 нь газар өмчлөх эрхийн, 5054 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлэг байна.

Газар өмчлөх эрхийн холбогдолдтой 22 төрлийн үйлчилгээний **10281** мэдүүлэг боловсруулж бүртгэл хийснээс

- Төрөөс үнэгүй өмчлүүлсэн газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 4560,
- гэрээ хэлцэлээр шинэ бүртгэл салж үүссэн анхны бүртгэл 41,
- төрөөс худалдаж авсан газар өмчлөх эрхээ бүртгүүлсэн 10,
- газар худалдах, худалдан авах гэрээний эрхийн бүртгэл 1060,
- газар бэлэглэлийн гэрээний эрхийн бүртгэл 299,
- өв залгамжлах эрхийн бүртгэл 129,
- хамтран өмчлөгч өөрчлөгдсөн бүртгэл 98,
- арилжаа солилцооны гэрээ 14,
- шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдсөн 2,
- өмчлөлийн газар барьцаалсан зээлийн гэрээний бүртгэл 1912,
- барьцааны гэрээ дуусгавар болгож цуцалсан бүртгэл 1269,
- үрэгдүүлсэн гэрчилгээ нөхөн олгосон бүртгэл 56,

- гэмтээсэн гэрчилгээ дахин олгох 4
- лавлагаа, хуулбар олгосон 707
- бусад өөрчлөлт хийгдсэн 120 бүртгэл хийж газар өмчлөх эрхийн 6342 гэрчилгээ, 692 лавлагааны үнэт цаас зарцуулсан байна.

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 25 төрлийн үйлчилгээний 5054 мэдүүлэг боловсруулж бүртгэл хийснээс

- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулах анхны бүртгэл 480
- Төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийг баталгаажуулах 90
- шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийн 156
- гэрээ хэлцэлийн үндсэн дээр бүртгэл салж үүссэн анхны бүртгэл 13
- төрөөс худалдаж авсан үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх бүртгүүлсэн байхгүй
- Худалдах худалдан авах гэрээний бүртгэл 256
- бэлэглэлийн гэрээ 60
- өв залгамжлах эрхийн гэрээний бүртгэл 50
- арилжаа, солилцооны бүртгэл 3
- хамтран өмчлөгч өөрчлөгдөх хэлцэл 63
- шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 3
- барьцаат зээлийн гэрээний бүртгэл 464
- барьцаалбартай барьцааны гэрээний бүртгэл 1389
- барьцааны гэрээ дуусгавар болгож цуцалсан бүртгэл 1187
- үрэгдүүлсэн гэрчилгээ нөхөж олгосон бүртгэл 21
- Түрээсийн гэрээ 1
- лавлагаа хуулбар олгосон 725
- бүртгэлд өөрчлөлт оруулсан бусад бүртгэл 93 бүртгэл тус бүр хийсэн байна.
- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн 1160 гэрчилгээ, 714 лавлагааны үнэт цаас зарцуулсан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийн орлогоос нийт **165,6 сая** төгрөг, үл хөдлөх худалдан борлуулсаны орлогоос хүн амын орлогын албан тавараас **352,1 сая** төгрөг, тэмдэгтийн хураамжаас **5,8 сая** төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт оруулсан байна.

ГХГЗЗГазар, УБЕГ-ын дундын мэдээллийн сангаас газар ашиглах болон эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэх 12606 хүсэлт ирүүлснээс /Э дугаар олгосон 11230, А дугаар олгосон 97/, нотлох баримт зөрөөтэй буцаасан 1090, хянагдах хуулийн хугацаа болоогүй хүлээгдэж буй 189 материал байна.

Тайлангийн хугацаанд газар өмчлөх эрхийн гэрчилгээ үрэгдүүлсэн 56, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ 21 нийт 77 гэрчилгээг хүчингүйд тооцуулах бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж, хувийн хэрэг хаалгах 18 хүсэлтийг нотлох баримтын хамт тус тус хүлээн авч УБЕГ-ын ЭХЭУБГ-т хүргүүлж ерөнхий бүртгэгчийн шийдвэр гаргуулан өмчлөгч нарт гэрчилгээг нөхөн олгож, бусад хувийн хэргийг хаах бүртгэл хийсэн.

1.2. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2020 онд нийт **11807** бүртгэл бүртгэсэнээс:

- Төрсний бүртгэл-1830
- Гэрлэсний бүртгэл-343
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл- 82
- Үрчлэлтийн бүртгэл- 44
- Эцэг тогтоосны бүртгэл- 78
- Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл -76
- Нас барсны бүртгэл-486
- Регистрийн дугаар өөрчлөлтийн бүртгэл-6
- Гэрчилгээ дахин олголт- 508
- Шинээр олгосон иргэний үнэмлэх-1156
- Дахин олгосон иргэний үнэмлэх-1895
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан- 2189
- Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл-46 тус тус бүртгэж, баталгаажуулсан байна.

Шилжилт хөдөлгөөний бүртгэл:

1. Аймаг, нийслэлээс шилжин ирсэн насанд хүрэгчид-1186
Хүүхэд-519
2. Сум дүүрэгт шилжин ирсэн насанд хүрэгч-336
Хүүхэд-221
3. Баг, хооронд шилжин ирсэн насанд хүрэгч-508
Хүүхэд-298 бүртгүүлсэн байна.

2020 онд Иргэний улсын бүртгэлийн цахим санд /онлайн/ мэдээлэл алдаатай эсвэл огт тусгагдаагүй **485** иргэний нотлох баримт, маягтуудыг ИУБГ-т албан бичгээр хүргүүлж зөрчлийг арилгасан. Үүнээс Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан 97 иргэдийн зөрчлийг бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр, мэдээллийн санд зөрчилтэй 372 иргэний зөрчлийг ИУБГ-т хүсэлт хүргүүлэн тус тус арилгууллаа. 16 нас хэтэрч иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан боловч нэрийн санд хаяггүй 19 иргэний хүсэлтийг хүлээн авч хаягжуулан иргэний үнэмлэхийг олгов.

2020 оны 01 дүгээр сард Иргэний бичиг баримтын үзлэг явуулах удирдамж чиглэлийг 27 суманд өгч хэсэгчилсэн /Ковид-19-ын нөхцөл байдалтай уялдуулан/ байдлаар үзлэгийг жилийн турш зохион байгууллаа. Аймгийн нийт сумдаас тодорхой шалтгааны улмаас Батсүмбэр, Баянцагаан, Сүмбэр сумд үзлэг зохион байгуулаагүй. Үзлэгт аймгийн 24 сумын 7100 өрхийн 19671 иргэн хамрагдаж зарим байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтануудын бичиг баримтад үзлэг хийж, багийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсгүүд томилогдон Хүн амын өрхийн сангийн мэдээлэл дээр тулгуурлан бичиг баримтыг шалган, тулгалт хийж ажилласан байна.

Түүнчлэн Борнуур, Заамар, Лүн, Эрдэнэсант сумд бичиг баримтын зөрчил арилгах **10 хоногийн аян** зохион байгуулан Баяннөжүүл, Баянцогт, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Эрдэнэсант сумд илэрсэн зөрчлийг **бүрэн** арилгасан.

Иргэний улсын бүртгэлийн Онлайн сүлжээнд холбогдсон зарим сумд иргэдийн мэдээллийг овог, эцэг/эх/-ийн нэр, нэрээр шүүн хаягийг шалган, хаяггүй байгаа иргэдтэй холбогдон бүртгэлийн хяналтын улсын байцаагч Ө.Налжирмаагийн дүгнэлтийг үндэслэн 11 иргэнийг хаягжууллаа.

Үзлэгээр 0-16 насны 2 хүүхэд, насанд хүрсэн 7 иргэн огт бичиг баримтгүй гэж бүртгэгдсэн бөгөөд зөрчил арилгах явцад Баян, Баянхангай, Жаргалант, Зуунмод, Сэргэлэн сумдын 7 иргэнийг бичиг баримттай болгосон.

Борнуур, Цээл сумдын огт бичиг баримтгүй 2 иргэн хаяг дээрээ тогтмол оршин суудаггүйгээс бичиг баримтжуулаагүй байна.

Иргэний бичиг баримтын үзлэг зохион байгуулсан жилийн эцсийн ажлын тайлан мэдээгээр бичиг баримт нь зөрчилтэй 419 иргэн бүртгэгдсний 381 иргэний зөрчлийг бүрэн арилгасан ба 38 иргэний зөрчил хувь хүнтэй холбоотой /байнга оршин суух хаяг дээрээ амьдардаггүй / шалтгаанаар хараахан арилаагүй байна.

Улсын бүртгэлийн хэлтэс бичиг баримтын зөрчил арилгах ажлыг зөвхөн хөдөө орон нутагт зохион байгуулах төдийгүй хэлтсийн хэмжээнд зөрчил арилгах арга хэмжээ авч ажилласны үр дүнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 381 иргэний бичиг баримтын зөрчлийг арилгаж, огт бичиг баримтгүй Батсүмбэр сумын харъяат Хойд овгийн Дүнээгийн Содномцэрэн /НБ62012014/, Мөнгөнморьт сумын иргэн Доржхандын Гэрэлмаа/НП75102005/ нарыг бичиг баримтжуулав. 16 нас хүрч иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан боловч нэрийн санд хаяггүй 26 иргэний хүсэлтийг хүлээн авч хаягжуулан иргэний үнэмлэхийг олгосон.

Тайлангийн жилд аймгийн хэмжээнд 16, 25,45 насны Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдах 3549 иргэн байсан бөгөөд тэдгээрээс 2020 оны 12 сарын 08-ны өдрийн байдлаар 2703 иргэн бүртгэлд хамрагдаж 849 иргэний хугацаа болоогүй, отрын бүс нутагт байгаа, орон нутагтаа амьдардаггүй, орон даяар хөл хорио тогтоосон зэрэг шалтгааны улмаас бүртгэлд хамрагдалгүй хүлээгдэж байна.

1.3. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2020 онд 176 хуулийн этгээд шинээр байгуулагдаж улсын бүртгэлд бүртгүүлсэнээс:

- ХХК-111,
- ТББ-16,
- Нөхөрлөл-27,
- Хоршоо-5,
- Төрийн байгууллага албан газар, УТҮГазар-14,
- ҮЭБ-2,
- Шашны байгууллага-1 тус тус бүртгүүлсэн.

Жилийн эцсийн байдлаар нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд нийт 1243 хуулийн этгээд бүртгүүлснийг ангилбал:

- Үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн-39,
- Гишүүн нэмэгдсэн, хасагдсан-21,
- Дүрэм шинэчилсэн-16,
- Дахин гэрчилгээ олгосон-38,
- Удирдлага өөрчлөгдсөн-35,
- Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн-41,
- Хаяг өөрчлөгдсөн-13,
- Дүрмийн сан нэмэгдсэн, хасагдсан-14,
- Нэр, хэлбэр өөрчлөгдсөн-3,

- Татан буугдсан-14,
- Хориг тавигдсан – 26,
- Эцсийн өмчлөгч бүртгүүлсэн – 983 /шинээр байгуулагдсан 176 хуулийн этгээд орсон/ хуулийн этгээд байна.

Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар 18 бүртгэгдсэнээс:

- ХК - 2
- /11/ХХК - 12
- /15/ХХК - 1
- /72/Холбоо - 1
- /19/ХХК - 1
- /69/ТБАГ - 1 байна.

Эцсийн өмчлөгчөө бүртгүүлсэн 983 хуулийн этгээдээс шинээр үүсэн байгуулагдсан 176, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд бүртгүүлсэн 807 хуулийн этгээд эцсийн өмчлөгчөө шинээр болон нөхөн бүртгүүлсэн.

Шинээр хуулийн этгээд байгуулахаар 176 иргэн оноосон нэр авч, шинээр байгуулагдсан болон тамга, тэмдгээ үрэгдүүлсэн, нэр, хэлбэр өөрчилсөн, тамга, тэмдэг нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон зэрэг шалтгаантай **197** хуулийн этгээдэд дахин давтагдахгүй дугаар бүхий хяналтын хуудсыг бүртгэлийн мэдээллийн санд бүртгэж олгосон.

2020 оны 10-р сарын 07-нд “Эцсийн өмчлөгчийн бүртгэл-100%” арга хэмжээг зохион байгуулах аяны удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан 27 сумын Засаг даргын тамгын газар, сумдын улсын бүртгэгч нарт хүргүүлж хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хуульд заасан хугацаанд бүртгүүлэх ажлыг зохион байгуулав. Аяны хүрээнд сумдад багийн Засаг дарга нар, сумын төрийн сангийн мэргэжилтэн, татварын улсын байцаагч, улсын бүртгэгч нарыг оролцуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байсан боловч Ковид19 цар тахлын улмаас улс даяар бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэх ажил удааширсан. Аян зарласнаас хойш аймгийн **983** хуулийн этгээд эцсийн өмчлөгчөө бүртгүүлсэн байна. Хуулийн этгээдийн “Эцсийн өмчлөгч”-ийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой болон Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орох, улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх материалын жагсаалтыг иргэд, сумын улсын бүртгэгч нар шууд авч хэрэглэх боломжтой байдлаар хэлтсийн <http://burtgel.to.gov.mn/> веб хуудас, “Төв аймаг Улсын бүртгэлийн хэлтэс” фэйсбук хуудсанд байршуулсан. Мөн холбогдох мэдээлэл, зөвлөмжийг сумдын улсын бүртгэгч нарт цаг алдалгүй утсаар болон цахим сүлжээ ашиглан өгч мэдээлэл солилцон ажиллав.

1.4. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

2020 оны жилийн эцэст улсын бүртгэлийн нийт 7337 бүртгэлд хяналт шалгалт хийж 219 зөрчил илрүүлж арилгасан. Мөн 2019 оны 12-р сарын 10-аас 2020 оны 01 сарын 31 хүртэл шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн 945 иргэний нотлох баримтад, 2020 оны 6-р сарын 25-наас 2020 оны 8-р сарын 14-ны өдрийг дуустал иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн 760 иргэний нотлох баримтад тухай бүр шалгалт хийж 20 иргэний шилжилт хөдөлгөөнийг улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүй болгосон.

Тайлангийн хугацаанд 178 улсын бүртгэлийн зөрчлийг улсын байцаагчийн дүгнэлтээр арилгав. Үүнээс:

- Иргэний улсын бүртгэлийн холбогдолтой-134
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн холбогдолтой-38
- Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлтэй -6 зөрчлийг тус тус шийдвэрлэсэн.

2020 онд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 399 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулах журмаар хянан шийдвэрлэж торгох шийтгэл оногдуулан нийт 8.970.000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн

2020 оны жилийн эцсийн байдлаар Жаргалант, Баян-Өнжүүл сумдад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж 160 иргэний бүртгэлийг хянаж 2 зөрчил, 119 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд шалгалт хийн 2 зөрчил, 24 сумын 251 иргэний улсын бүртгэлийн нотлох баримтын бүрдүүлбэрт түүвэрчилсэн шалгалт хийж 13 зөрчил илрүүлэн сумдын улсын бүртгэгч нараар зөрчлийг арилгуулсан. Жаргалант сумын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчид зөрчил арилган ажиллах хугацаатай албан шаардлага хүргүүлж бүртгэлийн зөрчлийг арилгуулсан

1.5. АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

2020 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хууль хяналтын байгууллагад 1537 лавлагаа, нотлох баримтын хуулбар, иргэнд 5693 лавлагаа тус тус олгож, албан хэрэгцээнд 509 лавлагаа гаргасан бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 73 лавлагаа иргэнд, 45 лавлагааг хууль хяналтын байгууллагад, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 1432 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар, хууль хяналтын байгууллагад 251 албан бичгээр лавлагаа тус тус олгосон.

Тайлангийн хугацаанд бусад аймаг, нийслэл рүү шилжин явсан 114 иргэний хувийн хэргийг шилжин очсон аймаг, нийслэл рүү хүрүүлэв.

2020 оны жилийн эцсийн байдлаар иргэний баримтын архивт хадгалагдаж байгаа **71492** иргэний хувийн хэрэг дэх **281828** ширхэг ИУБ-ийн маягтуудыг **786** хайрцагт савлан хадгаламжийн нэгжийн бүртгэлд оруулсан. Үүнээс ИУБ-31 маяггүй хувийн хэргийг ялган авч шалгасан ба нийт **41527** хувийн хэрэг шалгахад нас барсан **6806**, шилжсэн **24894**, харьяатаас гарсан **583**, тодорхойгүй, хүчингүй, мэдээлэл байхгүй **4995** буюу шалгасан нийт хувийн хэргийн **89.7%** нь УБ, бусад аймаг руу явах, хадгаламжийн нэгжийн өөр санд орох хувийн хэргүүд байна. Иргэний баримтын архив дахь нас барсан, тодорхойгүй, харьяатаас гарсан бүртгэлийн санг бүртгэлжүүлэх, тоолох үйл ажиллагаа эхлээд явж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт нийт 57671 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас газар өмчлөх эрхийн 47274, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10397 хувийн хэрэг байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2420 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнээс ХК-12, ХХК-1502, ТББ-261, ТӨААТҮГ-2, ОНӨААТҮГ-7, ТБАГ-231, нөхөрлөл-142, хоршоо-186, ХЗХ-8, Сан-8, ҮЭБ-44, Шашны байгууллагын 15, БСБ-4 хуулийн этгээдийн хувийн хэрэг байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын архивт байнга хадгалах хадгаламжийн нэгж 146, түр хадгалах 594, 70 жил хадгалах 23 хадгаламжийн нэгж тус тус хадгалагдаж байна.

2020 оны 1-р улиралд байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан хаагчдаас түр хадгалах 51, байнга хадгалах 13, 70 жил хадгалах 4 хадгаламжийн нэгжийг хүлээн авч бүртгэлд бүртгэн байгууллагын ББНШК (Баримт бичиг нягтлан шалгах комисс)-ын 2020 оны 03 сарын 25-ны өдрийн №02 дугаар хурлаар баталсан. Авилгатай тэмцэх газрын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 05/5036 тоот албан бичгээр ирүүлсэн хуулийн хэрэгжилт ханган ажиллах чиглэлийн дагуу 2008 оноос 2016 он хүртэлх Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэгийн нийт 8 ширхэг хадгаламжийн нэгжийг 2020 оны 05 сарын 20-ний өдөр тус хэлтсийн Баримт бичиг нягтлан шалгах комисст хүлээлгэн өгч байгууллагын архивт шилжүүлэн хадгаламжийн нэгжийг архивт байрлуулав. Баримт бичиг нягтлан шалгах комиссын 2020 оны 03 сарын 29-ний өдрийн №03 дугаар хурлаар хэлтсийн албан хаагчдийн “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг шинэчлэн хэлтсийн даргаар батлуулсан. Хэлтсийн дотоод хяналт шалгалтын комиссын ажлын төлөвлөгөөний дагуу 4-р сарын 02-ны өдөр “Төрийн архивын үндсэн заавар”, Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ыг үндэслэн хэлтсийн иргэний баримтын архив, эд хөрөнгийн баримтын архив, хуулийн этгээдийн баримтын архивт хяналт шалгалтыг хийлгэсэн. Уг шалгалтын хүрээнд 15 заалт бүхий зөвлөмжийг архивч нарт хүргүүлж хэрэгжилтийн ханган ажилласан. Мөн 2020 оны УИХ-ын сонгуулийн түр хадгалах 71 ширхэг хадгаламжийн нэгжийг байгууллагын архивт хүлээн авч акт үйлдсэн.

2020 оны 09 сарын 21-ны өдрийн ББНШК-ын №07 дугаар хурлаар байгууллагын баримт бичиг устгах ажлыг зохион байгуулсан бөгөөд хадгалах хугацаа дууссан 23468 хуудас, 30 хадгаламжийн нэгжийн жагсаалт үйлдэн Төв Чандмань ДЭХГ-ын шатаах зууханд устгалаа.

1.6.Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. УБЕГ-ын МТГ-аас ирүүлсэн нэг хаягт 10 ба түүнээс дээш сонгогч бүртгэгдсэн болон ижил овог нэртэй Төв аймгийн иргэдийн мэдээллийг филтэрдэн авч аймгийн 27 сум тус бүрээр файл үүсгэн хэлтсийн даргын 2019 оны 12 сарын 30-ны өдрийн 1366 тоот албан бичгээр сумын улсын бүртгэгч нарт хүргүүлж, ажлын чиглэл өгч ажиллав. Түүнчлэн сумын улсын бүртгэгч нь хүүхэд асрах чөлөөтэй байгаа Баянцагаан, Баянжаргалан, Угтаалцайдам, Баянхангай сумдын ЗДТГ-ын даргад хүсэлт хүргүүлж хамтран ажилласан

2. Сумын улсын бүртгэгч нар нэг хаягт 10 ба түүнээс дээш сонгогч бүртгэгдсэн өөрийн сумын иргэдийн мэдээллийг багийн Засаг дарга нартай хамтран өрхийн бүртгэлтэй нэг бүрчлэн тулгаж судалгааг нэгтгэн тухайн хаягт бүртгэлтэй иргэдээр гарын үсэг зуруулж, багийн Засаг даргын тодорхойлолтоор баталгаажуулж авсан.

3. Мөн сумын улсын бүртгэгч нар өөрийн сумын ижил овог нэртэй иргэдийн мэдээллийг багийн өрхийн бүртгэлтэй тулган, нягтлан шалгаж тухайн иргэнтэй юмуу эцэг, эхтэй нь холбоо барьж тодруулан, шаардлагатай тохиолдолд багийн Засаг даргаас тодорхойлолт гаргуулж авсан.

4. Төв аймгийн 27 сумдаас ирүүлсэн нэг хаягт 10 ба түүнээс дээш сонгогч бүртгэгдсэн болон ижил овог нэртэй иргэдийн мэдээллийг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргалаа. Үүнээс:

- Нэг хаягт 10 ба түүнээс дээш сонгогч бүртгэлтэй Төв аймгийн нийт 1166 иргэн байгаагаас хаягтаа амьдардаггүй 252, гадаадад амьдардаг 21, тухайн хаягт өрхийн мэдээллийн санд бүртгэлгүй 10, 12-р сард өөр хаягт шилжсэн 3 иргэн байна.

- Төв аймгийн ижил овог нэртэй гэх нийт 176 иргэний мэдээллийг шалгахад 60 иргэн нь овог нэр, төрсөн огноо ижил боловч өөр хүмүүс байна. Харин 116 нэр буюу 58 иргэн нь 2 регситрийн дугаартай байгааг илрүүлж ашигладаггүй, өөрчлөгдсөн регистрийн дугаарыг хүчингүй болгуулах хүсэлтийг хэлтсийн бүртгэлийн хяналтын байцаагчид гаргаж жагсаалтаар хүргүүлсэн.

5. Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хаяггүй, шилжин явсан боловч очсон газраа бүртгүүлээгүй нийт 140 иргэний мэдээллийг 27 сумын улсын бүртгэгч нарт хүргүүлэн багийн Засаг дарга нартай хамтран шалгаж 115 иргэнтэй холбогдон мэдээлэл хүргүүлснээр 2020 оны 01 сарын 31-ний өдрөөс өмнө 31 иргэний байнга оршин суух хаягийг бүртгэлээ.

6. Иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгж рүү шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 сарын 01-ний өдрөөс бүрэн зогсоож сумдаас 27 ширхэг шилжилт хөдөлгөөний бүртгэлийн журнал, 1309 ширхэг үлдэгдэл үнэт цаасыг 2020.01.31-ний байдлаар тулган, шалгаж акт үйлдэн хэлтэст хураан авч лацдан хадгаллаа.

7. Сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төвийн мэдээллийг цахим санд оруулах эрхийг хэлтсийн иргэний улсын ахлах бүртгэгч 1, улсын бүртгэгч 2, иргэний улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон сумын 11 улсын бүртгэгч нийт 14 албан хаагчид нээлгэж Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үеэр Төв аймгийн хэмжээнд ажиллах 27 сумын 96 санал авах байруудыг 2020 оны 03 сарын 13-ны өдөр гэхэд санд бүртгэж, баталгаажуулав. Санал авах байрууыг цахим санд бүртгэх гарын авлагыг сумдын улсын бүртгэгч нарт дотоод удирдлагын систем /ДУС/-ээр хүргүүлж, санал авах байрыг бүртгэх, шалгах талаар утсаар холбогдон заавар зөвлөгөө өгч ажилласан. Санал авах байруудын төвийг сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн **election.gasr.mn** хаягаар програмд оруулж, хаягийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн онлайн санд тулган шалгаж баталгаажууллаа.

8. Төв аймгийн 27 сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолыг програмд сканердан оруулсан.

9. Сумдын улсын бүртгэгч нараар програмын сонгогчдын нэрийн жагсаалт цэсэнд хэсэг оноогдсон өөрийн сумын иргэдийг тулгалт хийлгүүлж шалгууллаа. Хэсэг оноогдоогүй Цээл сумын 14, Заамар сумын 1 сонгогч байсан бөгөөд хаягийг санал авах байранд нэмж тусган хэсэг оноосон. Төв аймгийн 27 сумын 96 санал авах байранд нийт 63826 сонгогчид хэсэг оноолт хийгдсэн.

10. 2019.12.10-аас 2020.01.31-ний хооронд шилжин ирсэн 945 иргэний мэдээллийг мэдээллийн сан, журнал, маягттай тулган шалгаж жагсаалт үйлдэн, зөрчлийг тэмдэглэн хяналтын байцаагчид шилжүүллээ.

11. 2020.05.19-05.20-нд Төв аймгийн улсын бүртгэлийн байгууллагын нийт 103 итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн сургалтыг цахимаар зохион байгуулав.

12. СНЖ-ийн бүртгэлд хэсэг оноогдсон иргэдийг нягтлан шалгах ажлыг гүйцэтгэж, хэсэг оноогдоогүй иргэдэд хэсэг оноолоо.

13. 2020.05.27-28-ны өдрүүдэд улсын ахлах бүртгэгч П.Болормаагийн эрхээр УИХ-ын сонгуулийн 14-р тойргийн 96 хэсгийн СНЖ-ийг тус бүр 3% хэвлэж 2%-ийг хэсгийн хороодод зохих акт үйлдэн хүлээлгэн өглөө.

14. Хэсгийн хороодод ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудын СНЖ-д өөрчлөлт оруулах, сонгогч шилжих ажилд хяналт тавин ажиллаж нийт 765 лавлагаа хэвлэж СНЖ-д өөрчлөлт оруулсан.

15. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 14-р тойргийн 96 хэсгийн хороодод ажиллах 103 итгэмжлэгдсэн ажилтнуудад 2020 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Төв аймаг дахь Тагнуулын хэлтсийн хяналт, Цагдаагийн газрын хамгаалалтанд танхимын хэлбэрээр сургалт зохион байгуулж СНЖ-д өөрчлөлтийг тусган дахин 3% хэвлэж, тоног төхөөрөмжийг лацдан аймгийн Тагнуулын хэлтэст хүлээлгэн өгөв.

16. 2020.06.24-нд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн ирц бүртгэлийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж ирц бүртгэлийн мэдээг УБЕГ- тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

17. Сонгуулийн тоног төхөөрөмжийг УБЕГ-т бүрэн хүлээлгэн өгсөн.

1.7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төв аймгийн 27 сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн “Орон нутгийн хурлын сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг тогтоосон” тогтоолыг 2020 оны 05 сарын 22-23-нд улсын ахлах бүртгэгч П.Болормаа сонгогчдын нэрийн жагсаалтын удирдлагын програмд шивж оруулсан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд Төв аймгийн 27 сумын 97 багт ажиллах 98 хэсэг байгуулагдсан.

2. Сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төвийн мэдээллийг цахим санд оруулах эрхийг хэлтсийн иргэний улсын ахлах бүртгэгч 1, улсын бүртгэгч 2 албан хаагчид нээлгэж Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үеэр Төв аймгийн хэмжээнд ажиллах 27 сумын 98 санал авах байруудыг 2020 оны 06 сарын 13-ны өдөр гэхэд санд бүртгэж, баталгаажуулав.

3. Сонгогчийн нэрийн жагсаалтын удирдлагын програмд Төв аймгийн 27 сумын 98 хэсгийн мэдээлэл, хэсгийн дугаар, хэсэгт харьяалагдах хаяг болон тухайн хаяг дахь сонгогч хэсэгт зөв оноогдсон эсэхийг шалгахад ямар нэг алдаа, зөрүүтэй мэдээлэл гараагүй. Харин Баянчандмань суманд 3, Батсүмбэр суманд 2, Баяндэлгэр суманд 2, Баянхангай суманд 1, Зуунмод суманд 10, Заамар суманд 1, Эрдэнэсант суманд 1 нийт 21 иргэн хэсэггүй төлөвтэй байсныг санал авах байранд хаягийг нэмж бүртгэн хэсэг оноосон.

4. Хэлтсийн даргын 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн **684**, 08 дугаар сарын 11-ний өдрийн **849** дугаар албан бичгүүдээр сумдын улсын бүртгэгч нарт “Иргэний шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, баталгаажуулахад анхаарах асуудлаар” ажлын чиглэл хүргүүлж хяналт тавьж ажиллав. 2020 оны 06 сарын 25-ны өдрөөс хойш иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн нотлох баримт, ИУБ-22 маягыг бүртгэсэн тухайн өдөрт нь сумдаас PDF файлаар хүлээн авч шалган, баталгаажуулсан. Төв аймгийн хэмжээнд 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийг дуустал хугацаанд нийт 1210 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлснээс насанд хүрэгчид 760, хүүхэд 450 байна. Насанд хүрсэн **760** иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлээс аймаг, нийслэлээс шилжин ирсэн **407**, сумаас суманд шилжин ирсэн **113**, багаас багт болон баг дотроо шилжсэн **240** иргэн тус тус байлаа. Иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгж рүү шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 08 сарын 14-ний өдрөөс 10 дугаар сарын 16-ны өдөр хүртэл бүрэн зогсоож бүртгэлийн журнал, ИУБ-ийн маягыг хураан авч хяналт тавьж ажилласан.

5. Төв аймгийн улсын бүртгэлийн байгууллагын 98 итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн болон програмын сургалтыг цахимаар зохион байгуулав.

6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн Төв аймгийн 17 дугаар тойргийн 98 хэсгийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг тус бүр 3% хэвлэж хэсгийн хороодод зохих акт үйлдэн хүлээлгэн өглөө.

7. Хэсгийн хороодод ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудын СНЖ-д өөрчлөлт оруулах ажилд хяналт тавин ажиллаж нийт 38 лавлагаа хэвлэж СНЖ-д өөрчлөлт оруулсан.

8. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн Төв аймгийн 17 дугаар тойргийн 98 хэсгийн хороодод ажиллах 98 итгэмжлэгдсэн ажилтнуудад 2020 оны 10 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд Төв аймаг дахь Тагнуулын хэлтсийн хяналт, Цагдаагийн газрын хамгаалалтанд танхимын хэлбэрээр сургалт зохион байгуулж СНЖ-д өөрчлөлтийг тусган 3% хэвлэж, тоног төхөөрөмжийг лацдан аймгийн Тагнуулын хэлтэс, сонгуулийн хорооны албан хаагчдын хамтаар хэсгийн хороодод нэг бүрчлэн хүлээлгэн өгөв.

9. 2020.10.15-нд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн ирц бүртгэлийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж ирц бүртгэлийн мэдээг УБЕГ-тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үр дүнд Төв аймгийн Аргалант, Баянжаргалан, Мөнгөнморьт сумдын нэг нэг хэсэгт нэр дэвшигчдийн санал тэнцсэн тул нэмэлт санал хураалт явагдсан.

11. 2020 оны 10 сарын 27-нд Сонгуулийн тоног төхөөрөмжийг УБЕГ-т бүрэн хүлээлгэн өгсөн.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх УБЕГ-ын нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг тухай бүр бүрэн хэрэгжүүлж ажилласан. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн СНЖ үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, өөрчлөлт оруулах, иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгж рүү шилжин суурьших хөдөлгөнийг зогсоох, нээх болон сонгогчийн ирц бүртгэлийн үйл ажиллагааны үеэр тус хэлтэстэй холбоотой гомдол санал гараагүй. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үр дүнд Төв аймгийн Аргалант, Баянжаргалан, Мөнгөнморьт сумдын нэг нэг хэсэгт нэр дэвшигчдийн санал тэнцсэн тул нэмэлт санал хураалт явагдсан ба нэмэлт санал хураалтын явцад ямар нэг алдаа дутагдал гараагүй.

ХОЁР. ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН АЖЛЫН БАЙРНЫ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

2.1 Сургалтын үйл ажиллагаа

2020 онд зохион байгуулах хэлтсийн сургалтын төлөвлөгөөг 12 заалттайгаар боловсруулан гаргаж хэрэгжилтийг ханган ажиллав. Тайлангийн хугацаанд дараах сургалтыг зохион байгуулж холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулсан. Үүнд:

А/Дотоодын онлайн сургалт

- 2020 оны 01 дүгээр сард төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан гаргах тухай иргэний улсын ахлах бүртгэгч П.Болормаа 27 сумын улсын бүртгэгч болон хэлтсийн төрийн захиргааны 10 албан хаагч нарт,
- Хэлсийн иргэний бүртгэлийн тасгийн архивч Ж.Энхжаргал 2020 оны 04 сарын 08-ны өдөр онлайн сүлжээнд холбогдсон 12 сумын иргэний бүртгэлийн улсын бүртгэгч нарт “Улсын бүртгэлийн архивын нэгдсэн систем”-ийг хэрхэн ашиглах талаар,
- 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуультай холбогдуулан улсын бүртгэлийн байгууллагын нийт 103 итгэмжлэгдсэн ажилтнуудад онлайнгаар,
- 2020 оны 06 сарын 4-ний өдөр хэлтсийн 19 албан хаагчдад “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдвээр хүний эрхийн үндэсний комиссын референт Х.Цэцгээгийн бэлтгэсэн онлайн сургалт
- 2020 оны 09 сарын 15-нд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд ажиллах 98 итгэмжлэгдсэн ажилтнуудад онлайн сургалт тус тус зохион байгуулсан.

- 2020 оны 12 сарын 14-нд Төв аймгийн 27 сумын газрын даамлуудад “Дундын мэдээллийн санд бүртгүүлсэн газар эзэмших ашиглах эрхийн нотлох баримтын бүрдүүлбэр, анхаарах асуудал” сэдвээр онлайн сургалт зохион байгуулав.

Б/ Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан онлайн сургалт

- 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэргэжилтэн Ш.Уртнасангийн “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн хийж боловсруулах тухай” онлайн сургалтад хэлтсийн төрийн захиргааны 12 албан хаагчид,
 - 2020 оны 03 сарын 06-ны өдөр УБЕГ-аас “МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн танилцуулга, мэдээлэл, сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх” тухай програмын сургалтанд Иргэний бүртгэлийн тасгийн дарга П.Болормаа,
 - 2020 оны 03 сарын 23-ны өдөр “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд гарч буй нийтлэг зөрчлийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ”–ний тухай онлайн сургалтанд Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 5 улсын бүртгэгчид,
 - 2020 оны 03 сарын 30-ны өдөр УБЕГ-аас “Хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах” тухай онлайн сургалтанд хэлтсийн эцэг, эхийн зөвлөлийн 5 гишүүд,
 - 2020 оны 04 сарын 08-ны өдөр УБЕГ-аас “МУИХСонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах” тухай сургалтанд иргэний бүртгэлийн тасгийн дарга П.Болормаа,
 - 2020 оны 04 сарын 15-16-ны өдрүүдэд УБЕГ-аас зохион байгуулсан “Удирдах ажилтны нэгдсэн сургалт”-нд хэлтсийн дарга, тасгийн 2 дарга нар,
 - 2020 оны 04 сарын 22-ны өдөр “Иргэний улсын бүртгэлийн систем”-ийн танилцуулга, зөвлөмж, бүртгэл хөтлөлтөд анхаарах асуудлууд” сургалтанд иргэний бүртгэлийн тасгийн дарга Д.Болормаа,
 - 2020 оны 04 сарын 30-ны өдөр “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн анхаарах асуудал” сургалтанд хуулийн этгээдийн улсын бүртгэгч Т.Батчимэг,
 - 2020 оны 05 сарын 26-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” цахим сургалтанд хэлтсийн дарга Н.Энхбат, иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч П.Болормаа, хяналтын улсын байцаагч Б.Баярцэцэг, эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч Ш.Батсүх нар,
 - 2020 оны 09 сарын 18-нд УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газраас зохион байгуулсан “Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн анхаарах асуудлууд” цахим сургалтанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Ц.Энхчимэг, Д.Дуламсүрэн, Б.Батцэнгэл нар,
 - 2020 оны 10 сарын 19-нд УБЕГ-аас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль” цахим сургалтанд хяналтын улсын байцаагч Б.Баярцэцэг, архивч Ж.Энхжаргал нар,
 - 2020 оны 11 сарын 4-нд УБЕГ-аас зохион байгуулсан “Цахим архиваас лавлагаа олгох” сэдэвт цахим сургалтанд иргэний бүртгэлийн улсын бүртгэгч С.Мөнхзул, У.Тэмүүл нар тус тус хамрагдлаа.

В/ Танхимын сургалт

- Аймгийн засаг даргын тамгын газрын хууль эрх зүйн хэлтсээс “Үндсэн хууль” баталсан өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай 2020.01.03 ны өдрийн 04/23 тоот албан бичгийн дагуу хэлтсийн 19 албан хаагчдын дунд “Монгол ёс заншилаа хадгалъя” сэдэвт 3 төрлийн шагайн тэмцээнийг зохион байгуулж Үндсэн хуулийн шинэчлэл сэдвээр,
 - Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран 2020 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Монгол улсын их хурлын сонгуулийн 14 дүгээр тойргийн 96 хэсэгт ажиллах 103 итгэмжлэгдсэн ажилтнуудад, 2020 оны 10 сарын 02-03-ны өдрүүдэд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн


Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн 98 хэсэгт ажиллах 98 итгэмжлэгдсэн ажилтнуудад сонгуулийн санал авах өдөр сонгогчийн бүртгэлийн програм хангамжийг ажиллуулах, сонгогчийн хувийн мэдээллийг нягтлан шалгах, ирцийн мэдээ, бүртгэлийн хуудас хэвлэх дадлага хийх, сонгогчдын нэрийн жагсаалтанд өөрчлөлт тусгах лавлагааг ирц бүртгэлийн програмд оруулах, сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх, ирц бүртгэлийн програмыг түгжих, тоног, төхөөрөмжийг хүлээлцэхтэй холбоотой үйл ажиллагааны талаарх сургалт,

- 2020 оны 10 дугаар сарын 03-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын сургалтын баг хэлтсийн нийт 50 албан хаагчдад улсын бүртгэлийн холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, бүртгэл хөтлөхөд гарч буй хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга зүйн талаар бүсийн сургалт тус тус зохион байгуулав.

УБЕГ-аас зохион байгуулсан 12 онлайн сургалт, хэлтсээс зохион байгуулсан 6 онлайн сургалт, танхимын 4 удаагийн сургалтанд хэлтсийн албан хаагчид, сумдын улсын бүртгэгчид болон улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнууд зэрэг давхардсан тоогоор нийт **606** албан хаагчдыг бүрэн хамруулав.

2.2 Байгууллагын сурталчилгаа

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог хангах зорилгоор иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаар болон бүртгэлийн үйлчилгээний сар бүрийн статистик тоон мэдээ, Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх материалын жагсаалт, хэлтэст ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээгээр тус тус инфографик мэдээлэл бэлтгэн хэлтсийн цахим хуудас сошиал сүлжээ <https://tuv.burtgel.gov.mn/>, “Төв аймаг Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудсанд байршуулан олон нийтэд түгээж байна. Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх зөвлөгөө, мэдээлэлийг хэлтсийн <https://www.facebook.com/tuvburtgel/> page хуудасны автомат хариулагч буюу **BurtgelBot** програм хангамжаас авах боломжийг нэвтрүүлэн ажиллаж байна. **BurtgelBot** нь бусад төрлийн аппликешнтэй харьцуулахад цаг хугацааны хамааралгүйгээр, гарт ойр, ашиглахад хялбар байхаас гадна улсын бүртгэлийн холбогдолтой бүхий л мэдээ мэдээллийг иргэд авах боломжтой юм. Улсын бүртгэлийн хэлтсээс 2020 онд үзүүлсэн үйлчилгээний талаарх **236** инфографик мэдээлэл иргэдэд хүрсэн.



Түүнчлэн Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгт зориулан Иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч П.Болормаа Монгол Улсын Их Хурлын сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа түүнтэй холбогдуулан иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгж рүү шилжин суурьших хөдөлгөөнийг зогсоох, сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн мэдээлэлтэй хэрхэн танилцах, иргэний улсын бүртгэлийн зөрчил арилгах чиглэлээр хэлтсээс зохион байгуулж буй үйл ажиллагааг танилцуулж аймгийн телевизийн “Зочины цаг” нэвтрүүлэгт 2 удаа оролцож, 1 удаа ярилцлага өглөө. 11-р сард хэлтсийн дарга Н.Энхбат аймгийн Төв телевизийн зочны цаг нэвтрүүлэгт оролцож бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Улсын бүртгэлийн хэлтсийн ажиллах цагийн хуваарь болон бусад хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагааны талаар мэдээ мэдээлэл хийлээ.

2.3 Вэб баяжилт

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг [ХЭЛТСИЙН ВЕБ](#) хуудсанд байршуулж бүртгэлийн тоон мэдээ, цаг үеийн чанартай хийж хэрэгжүүлсэн ажлуудын мэдээллийг байнга шинэчилэн олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

- <http://burtgel.to.gov.mn/> 2020.01.01-2020.11.01 хугацаанд 236 мэдээ мэдээллийг нийтэлсэн.
- <https://tuv.burtgel.gov.mn/> 2020.11.01 өдрөөс эхлэн Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн шинэ платформыг хөгжүүлэн 96 мэдээ оруулсан.
- Хэлтсийн мэдээллийн самбарт 90 зөвлөгөө мэдээлэл байршуулсан
- <https://www.facebook.com/tuvburtgel> facebook хуудсанд 272 мэдээ нийтэлсэн зэрэг

нийт **604** мэдээ, пост оруулсан байна

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хэлтсийн мэдээллийн ил тод байдлыг хангах, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан ажлын тайлан:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог хангах зорилгоор иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаар болон бүртгэлийн үйлчилгээний сар бүрийн статистик тоон мэдээ, Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх материалын жагсаалт, хэлтэст ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээгээр тус тус инфографик мэдээлэл бэлтгэн хэлтсийн цахим хуудас сошиал сүлжээ <http://burtgel.to.gov.mn/>, “Төв аймаг Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудсанд байршуулан олон нийтэд түгээж байна. Түүнчлэн Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүрдүүлэх материалын жагсаалт, **e-barimt аппликейшн** ашиглан үйлчилгээний төлбөр төлөх заавар зэргээр гарын авлага /боршур/ бэлтгэн иргэдэд тараасан.

Иргэдэд Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх зөвлөгөө мэдээлэл өгөх албан хаагчдын утасны дугаарыг хэлтсийн <http://burtgel.to.gov.mn/> веб хуудас, <https://www.facebook.com/tuvburtgel/> Фэйсбук хуудсанд байршуулан олон нийтэд хүргэсэн.

2020 онд Жаргалант, Лүн, Эрдэнэсант, Борнуур сумдад хэлтсийн “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулж, Эрдэнэ, Баяндэлгэр, Баян, Баянцогт сумдад аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан хууль хяналтын байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т хамтран оролцож нийт дүнгээр 250 гаруй мэдүүлэг хүлээн авч давхардсан тоогоор 820 гаруй иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

3.2 Санхүүгийн үйл ажиллагааны тайлан:

Хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн удирдаж цалин, НДШ-тэй холбоотой төсөв санхүүгийн асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. ХХОАТ болон НДШ-ийн өр байхгүй. 2021 оны төсвийн төсөл 2022-2023 оны төсвийн төсөөллийн саналыг 6 сарын 15-нд нэмэлт судалгаатай хамт УБЕГ-т хүргүүлсэн. Мөн байгууллагын санхүүгийн тайланг цаг хугацаанд нь УБЕГ-т хүргүүлсэн. Хугацаа хоцроосон санхүүгийн тайлан, мэдээ байхгүй.

2020 оны 11 сарын 30-ны байдлаар 604,665,900 төгрөгийн санхүүжилт авч 594,110,156.51 төгрөгийн зарцуулалт хийж 10,555,743,49 төгрөгийн үлдэгдэлтэй ажиллаж байна. Үүнд:

- Цалин 290,014.14 төгрөг хэмнэгдсэн
- НДШ-ийн 3,324,919.35 төгрөг хэмнэгдсэн
- Байр ашиглалттай холбоотой зардалд 4,654,730 төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардалд 1,065,600 төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 150,080 төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардалд 1,021,500 төгрөг
- Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал 48,900 төгрөг үлдэгдэлтэй байна.

Өглөг, авлага байхгүй. 2020 оны 1-ээс 3 дугаар улирлын харилцахын болон бараа материалын тайланг үдэж архивын нэгж үүсгэсэн. Аcolous болон цалингийн программыг бүрэн ашиглаж байна. Мөн 2013-2019 онуудад санхүүгийн тайлангийн аудитаар **зөрчилгүй** санал дүгнэлт авсан.

2020 оны эхний хагас жилийн тооллогоор 5577.3 мян төгрөгийн бичиг хэрэг, 22800.6 мян төгрөгийн бусад материал, 24040.2 мян төгрөгийн үнэт цаас, 1,112,590.8 мян төгрөгийн үндсэн хөрөнгийг нүд үзэн тоолсон. Тооллогын явцад дутагдсан үрэгдсэн хөрөнгө гараагүй. Хэлтсийн 48 албан хаагч бүрт эд хөрөнгийн карт хөтлүүлж эд хөрөнгийг хариуцуулсан. Байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэлээр 2019 оны жилийн эцсийн тооллогоор санал болгосон актлах хөрөнгийн саналыг УБЕГ-т 03 сарын 20-нд хүргүүлсэн бөгөөд ТӨБЗГазрын 2020 оны 6 сарын 17-ны өдрийн А-1/1107 тоот албан бичгээр 63,400,158,18 төгрөгийн хөрөнгө актлах зөвшөөрлийн дагуу 9 сарын 15-нд акталсан. 27 сумын улсын бүртгэгчдээс үнэт цаасны тайланг сар бүрийн 25-нд тасалбар болгон авч сар бүрийн 5-ны дотор нэгтгэн УБЕГ-т хүргүүлж байна. Мөн санхүүгийн программд 40 улсын бүртгэгчдэд нярав үүсгэн тооцоо бодож байгаа болно. Түүнчлэн сар бүрийн 5-ны дотор УБЕГ-т цахим үнэмлэхний тоон болон орлогын мэдээг хүргүүлэн ажиллав. 2019 оны 13 нэр төрлийн 1066 ширхэг хүчингүй үнэт цаасыг Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэн УБХ-ийн даргын А/14 тушаалаар акталж устгасан. Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийж ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллав.

2020 оны 11 сарын 30-ны байдлаар шилэн дансны цахим сайтад 120 мэдээлэл оруулсан.

3.3. Хүний нөөцийн үйл ажиллагааны тайлан:

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан орон тооны хязгаарт багтаан төрийн захиргааны /ТЗ/ 40, төрийн үйлчилгээний /ТҮ/ 5, гэрээт 5 нийт 50 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Албан хаагчдын 2020 оны 1, 2-р улирлын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр хангалтай сайн үнэлэгдсэн ТЗ-ны 16, ТҮ-ний 3 албан хаагчид хэлтсийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Б/03 тоот тушаалаар 2,750,000 төгрөгийн урамшуулал, 2020 оны 07 сарын 09-ны өдрийн Б/11 тушаалаар ТЗ-ны 13, ТҮ-ний 4 албан хаагчид 2,390,000 төгрөгийн урамшуулал тус тус олгосон. Мөн 2020 оны 11 сарын 11-ний өдрийн А/20 тушаалаар хэлтсийн улсын бүртгэгч Г.Ундрахбаяр, С.Мөнхзул нарт шинээр гэр бүл болсонд зориулж 1 удаагийн тэтгэмж 400,000 төгрөг олгосон.

Тайлангийн хугацаанд төрийн мэргэшсэн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилохдоо мерит зарчмыг удирдлага болгон ажиллахад анхаарч сул орон тоо гарсан тохиолдолд хэлтэст ажиллаж байгаа албан хаагчид болон сумын ЗДТГ-т ажиллаж байгаа албан хаагчдаас томилуулах чиглэл барьж ажилласан. Энэ ажлын хүрээнд УБЕГ-н Төв архивт ажиллаж байсан албан хаагчийг хуулийн этгээдийн улсын бүртгэгчээр, Цээл сумын нийгмийн бодлогын

мэргэжилтнээр ажиллаж байсан албан хаагчийг сумын улсын бүртгэгчээр, Мөнгөнморьт сумын төрийн сангийн мэргэжилтэнг сумын улсын бүртгэгчээр, Баянчандмань сумын хууль эрх зүйн мэргэжилтэнг сумын улсын бүртгэгчээр, хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивчийг улсын бүртгэгчээр, Угтаалцайдам сумын улсын бүртгэгчийг хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчээр тус тус томилуулав. Хүний нөөцийн цахим системд албан хаагчдын цалин, хөдөлгөөн, бусад мэдээллийг тогтмол шинэчлэн оруулж байгаа бөгөөд шинээр томилогдсон албан хаагчдын мэдээллийг нэмж, томилогдсон болон чөлөөлөгдсөн тушаал шийдвэрийг сканердан оруулж байна. Түүнчлэн хүний нөөцийн тайланг УБЕГ-аар дамжуулан Төрийн албаны салбар зөвлөлд тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

3.4. Хэлтэст ирсэн явсан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт:

Тайлангийн хугацаанд тус хэлтэст нийт 107 өргөдөл гомдол бүртгэсэнээс

- Иргэний бүртгэлтэй холбоотойгоор гэрчилгээ дахин авах, үрчлэлт, гэрлэлтийн бүртгэл, овог эцэг /эхийн/ нэр, өөрийн нэр өөрчлөлтийн бүртгэл, хаягын мэдээлэл гэх мэт бүртгэлийг мэдээллийн санд оруулахыг хүссэн – 12,
- Эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотойгоор үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл хийлгэж өмчлөх эрхийн гэрчилгээ авахыг хүссэн -13,
- Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой – 2,
- Бүртгэлийн зөрчил хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор алдаатай бичигдсэн бүртгэлийг засуулах, регистрийн дугаар тогтоолгох, бүртгэл нөхөн хийлгэхийг хүссэн -19,
- Албан хаагчдаас ирүүлсэн хүний нөөцтэй холбоотой ажлаас чөлөөлөгдөх, цалинтай чөлөө хүссэн, ээлжийн болон жирэмсний амралт хүссэн -19,
- Албан хаагчийн ёс зүй, харилцаатай холбоотой -3,
- Иргэний баримтын архиваас хувийн хэргийн мэдээлэл лавлагаа хүссэн -35,
- Санхүүгийн асуудлаар тэмдэгтийн хураамжийн буцаан олголт хүссэн -1,
- ТҮЦ машинтай холбоотой -1 ,
- Шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой – 2 өргөдлийг бүртгэн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг хүргүүлсэн.

Хугацаа хоцроож шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй.

2020 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 1025 бичиг ирсэн ба 1222 албан бичиг явуулсныг бүртгэж бүртгэл хөтлөн, ДУС-ын албан бичгийн бүртгэлд бүртгэн дугаарлаж хяналтын карт хэвлэсэн. Нийт ирсэн бичгээс 659 хугацаатай, хариутай бичиг байсан. Үүнд:

- УБЕГ ирүүлсэн албан бичиг – 27
- УБЕГ ирүүлсэн зөвлөмж, чиглэл, мэдээлэл – 49 /Иргэний бүртгэлийн чиглэлээр -17, Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр- 6, нийт албан хаагчдад - 5, бүртгэлийн хяналт – 4 , санал судалгаа хүссэн – 6, Сонгуультай холбоотой – 4, албан шаардлага - 1 /
- Аймгийн ИТХ, ЗДТГ болон Засаг дарга, захиргааны байгууллагаас - 30
- Нийслэлийн болон аймгийн ШШГАлбанаас – 199 /аймгийн ШШГГ - 107, БХЗХТБАА - 16, нийслэлийн ШШГГ –76/
- Аймаг нийслэлийн цагдаагийн албанаас – 281
- Шүүхийн байгууллагаас- 159
- Аймаг нийслэлийн УБХ – 181/ аймаг – 146 , нийслэлээс - 35/
- Бусад байгууллагаас- 74

- Төв аймгийн Прокурорын газраас – 19
- Тагнуул - 5
- Төв аймаг дахь Татварын хэлтсээс - 3

Эдгээр хугацаатай, хариутай албан бичгээс аж ахуйн нэгж, иргэний нэр дээр эд хөрөнгийн лавлагаа мэдээлэл хүссэн 247, иргэний бүртгэлийн лавлагаа хүссэн 221, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа хүссэн 56, үл хөдлөх эд хөрөнгийн эрх түдгэлзүүлэх 81, эрх сэргээх 43, судалгаа мэдээлэл хүссэн 11 албан бичиг байсан. Хугацаа хоцорсон албан бичиг 3, шийдвэрлэх хугацаа болоогүй хяналтанд байгаа 5 албан бичиг тус тус байна.

2020 оны жилийн эцэст тус хэлтэст УБЕГ-ын даргын /А/ тушаал 25 батлагдан ирсэн. Үүнд шилжилт хөдөлгөөн түр зогсоох тухай 3, журам батлах тухай 8, ажлын хэсэг байгуулах тухай 2, дүрэм хүчингүй болгосон тухай 1, ажлын тусгай горимд шилжүүлсэн тухай 3, итгэмжлэгдсэн ажилтны орон тоо баталсан 2, зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 1, албан тушаалын тодорхойлолт батлах тухай 1, албан томилолтоор ажиллуулах тухай 1, шуурхай баг ажиллуулах тухай 1 тушаал тус тус ирүүлснийг хүлээн авч биелэлтийг ханган ажиллаж байна. Харин /Б/ тушаал 31 батлагдан ирсэн ба үүнээс ажлаас чөлөөлсөн 7, цалин шинэчлэн тогтоосон 1, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай 2, туршилтын хугацаагаар ажилд томилсон 2, ажилд томилсон 8, ажилд шилжүүлсэн тухай 8, зэрэг дэв олгосон тухай 1, ээлжийн амралтын хуваарь батлах тухай 1, гэрээгээр ажил гүйцэтгүүлэх 1 тушаал тус тус батлагдан ирсэн байна.

Тайлангийн хугаанд хэлтсийн даргын А тушаал 23, Б тушаал 18 батлагдан гарсан байна. Үүнээс ажлаас чөлөөлсөн 4, гэрээт ажилтан томилсон 6, урамшуулал олгох тухай 3, шилжүүлэн томилсон 3, ажил хавсруулан гүйцэтгүүлэх 1, ажил хүлээлцэх тухай 1 тус тус батлан гарсан Хүний нөөцийн томилгоотой холбоотой өргөдөл, гомдол байхгүй.

УБЕГ-аас холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг шинэчлэх төсөлд тус хэлтсээс:

1. 2020.04.15-ны өдөр №412 албан бичгээр байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгуулах 8 санал,
2. 2020.04.23-ны өдөр №458 албан бичгээр иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын баримтыг хадгалах хугацааны салбарын жагсаалтад тусгуулах 14 санал,
3. 2020.05.06-ны өдрийн №506 албан бичгээр “Улсын бүртгэлийн байгууллагын хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны явцад хяналт тавих журам”-д тусгуулах 2 санал,
4. 2020.06.11-ны өдрийн №669 албан бичгээр архивч-судлаач нарт нэг удаагийн тэтгэмж олгох эрх бүхий албан хаагчийн санал
5. 2020.12.08-ны өдрийн №1234 тоот албан бичгээр “Монгол улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын төсөлд тус тус хугацаа хоцроолгүй хүргүүлж ажилласан.

2020 оны эхний хагас жилд тус хэлтэстэй холбоотой хууль шүүхээр шалгагдаж байгаа хэрэг, маргаан байхгүй

3.5. Хууль тогтоомж, байгууллагын үйлчилгээний стандарт, Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангах, мэдээ, тайлан хүргүүлсэн байдал, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах талаар хийж хэрэгжүүлсэн ажил

Хэлтсийн даргын 2020 оны 01 сарын 02-ны өдрийн А/01 тоот “Сахилга хариуцлага, дэг журам, үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай” тушаалаар хэлтсийн нийт албан хаагчдад төрийн албаны хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримталж, үйлчилгээнийхээ чанар хүртээмжийг нэмэгдүүлж ажиллахыг үүрэг болгож хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. 2020 онд хэлтсийн албан хаагчидтай холбоотой төрийн албаны хууль тогтоомж зөрчсөн болон ёс зүйн зөрчил гаргасан гэх өргөдөл гомдол ирээгүй.

Улсын бүртгэлийн сар бүрийн тоон мэдээ, тайланг УБЕГ-ын ИУБГ, ЭХЭУБГ, ХЭУБГ-т болон улсын бүртгэлийн Төв архивын газарт хугацаанд нь хүргүүлж байна. Түүнчлэн цаг үеийн хийж хэрэгжүүлсэн томоохон ажлын тайлан, илтгэх хуудсыг тухай бүр УБЕГ-ын холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн. Тайлангийн хугацаанд УБЕГ-ын ИУБГ-аас ирүүлсэн хугацаатай хариутай, чиглэл хүргүүлсэн нийт 36 албан бичиг, дотоод албан бичгийг хяналтад авч хариуг хугацаанд нь хүргүүлж ажиллав. Энэ ажлын хүрээнд ИУБГ-т 14 удаагийн илтгэх хуудас хүргүүлж хийж хэрэгжүүлсэн ажлаа тухай бүр тайлагнасан. Дээд газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн дагуу сумын улсын бүртгэгч нарт 10 удаагийн албан бичиг, 1 удирдамж, 3 дотоод албан бичиг, 4 удаагийн сургалтын хөтөлбөр хүргүүлж ажлын чиглэл өгч хэрэгжилтийг тооцон ажиллав. Мөн сумын улсын бүртгэгч нарын бүртгэсэн ИУБ-ийн маягтыг мэдээллийн санд нэг бүрчлэн шалгаж илэрсэн зөрчлийг хяналтын улсын байцаагчид тэмдэглүүлж, сумын улсын бүртгэгч нараар зөрчлийг арилгуулсаны дараа санд баталгаажуулж ажиллав. Тайлангийн хугацаанд нийт 183 улсын бүртгэлийн зөрчлийг илрүүлж, зассаны дараа мэдээллийн санд баталгаажуулсан байна.

Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцан техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллаа. Улсын бүртгэлийн мэдээллийн санг болзошгүй аюул, кибер халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, мэдээлэл алдагдахаас сэргийлж сүлжээнд холбогдсон тоног төхөөрөмж, компьютерийн интернэтийн болон дотоод флаш оролтыг хааж бүх компьютерүүдийн firewall буюу галт ханыг идэвхжүүлэн Windows defender үйлдлийн системд суугдсан бүрэлдэхүүнийг ашиглан вирус, скрипт, бусад аюултай програмууд гэх мэт хортой програмуудаас компьютерийг хамгаалсан. Хэлтсийн шинэ сүлжээг интернэт сүлжээнээс салган тусдаа кабелиар авдаг боллоо. Түүнчлэн серверийг тусад нь зориулалтын өрөөнд байршуулж лацдан үүдний хэсгийг камерын хяналтанд оруулсан. 2020 онд 27 сумын иргэний бүртгэлийн Civilreg Offline програмын хаягийн санд update хийж бүх хаягийг шинэчилсэн. Интернэт сүлжээ болон Улсын бүртгэлийн сүлжээний гэмтэл, саатлын дэвтэр гарган хөтөлж, тухай бүр тэмдэглэл үйлдэн ажиллав. Тайлант хугацаанд хэлтсийн дотоод болон гадаад сүлжээний нийт 37 удаагийн тасалдлын гэмтэл шалтгааныг тодруулан сүлжээг хэвийн ажиллагаанд оруулсан.

Хэлтсийн даргын 2020 оны 02 сарын 28-ны өдрийн А/05 Гамшгаас хамгаалах алба байгуулах тухай тушаалаар албан хаагч, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн байгууллага, онцгой комиссын шийдвэрийг биелүүлэх шаардлага зөвлөмжийг тогтмол тавьж ажиллах үүрэг бүхий хариуцлагатай албыг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж онцгой байдлын үед ажиллах ажлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулалтыг хийн ажиллаж байна. Мөн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед байгууллагын халдвар хамгаалалтыг шалгах, ажлын байранд жижүүрлэн ажиллах албан хаагчдын хуваарийг гарган ажиллалаа. Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн яамны шийдвэр, Улсын онцгой комиссын шийдвэр, аймгийн онцгой комиссын хурлын тэмдэглэл, ковид19 халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж зэргийг иргэдэд танилцуулах зорилгоор хэлтсийн угтах хэсэгт байрлуулсан. Төв аймгийн Онцгой комисст хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаарх илтгэх хуудсыг тогтсон хугацаанд хүргүүлж, ирүүлсэн заавар зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хэлтсийн

угтах үйлчилгээнд гар ариутгагч болон нойтон салфетка байрлуулж үйлчилгээний танхимд үйлчлүүлэхээр ирсэн иргэдийн бүртгэлийг хөтөлж халууныг хэмжин, амны хаалтаа зүүхийг сануулж, гарыг нь ариутгуулж үйлчилж байна. Мөн үйлчилгээний зааланд зай барих зураас байрлуулж иргэдэд анхааруулж хэвшлээ.

2020 оны 12 сарын 01-ний өдрөөс эхлэн Ebarimt аппликейшнийг ашиглан тус хэлтэст үйлчлүүлсэн иргэдээр QR код уншуулж үйлчилгээ үзүүлж байна. Ковид19 өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмж, эрүүл мэндийн зөвлөгөө, халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудсыг хэлтсийн байранд болон байгууллагын цахим хуудсанд тогтмол байрлуулж мэдээ, мэдээллийг шинэчлэн иргэд, олон нийтэд сурталчилж ажиллав.

3.6 Аймаг, орон нутгийн бусад байгууллагуудтай хамтран ажилласан байдал:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газар, Азийн хөгжлийн банк /ADB/-тай хамтран хэрэгжүүлж буй "Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор улсын бүртгэлийн системийг боловсронгуй болгох" төслөөр 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс тус аймгийн сумдыг иргэний улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбох ажлыг эхлүүлж [Архуст](#), [Баяндэлгэр](#), [Эрдэнэ](#), [Алтанбулаг](#), [Батсүмбэр](#), [Өндөрширээт](#), [Бүрэн](#), [Дэлгэрхаан](#), [Эрдэнэсант](#), [Заамар](#), [Сэргэлэн](#), [Баянхангай](#), [Баянцогт](#) зэрэг 13 сумыг сүлжээнд холбосон. 2020 оны эхний хагас жилд [Аргалант](#), [Угтаалцайдам](#), [Цээл](#) сумдыг сүлжээнд холбосноор Төв аймгийн нийт 19 сум иргэний улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдоод байна. 2020 оны 09 дүгээр сард Баянцагаан, Баянчандмань сумдыг онлайн сүлжээнд холбох тоног төхөөрөмжийг бэлдсэн боловч Баянцагаан сумын улсын бүртгэгч хүүхэд асрах чөлөөтэй, Баянчандмань суманд мэдээлэл холбоо сүлжээний өргөтгөл хийгдээгүй зэрэг шалтгаанаас сүлжээнд холбох ажил түр хойшлогдоод байна.

2. Монгол Улсын Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус хэлтсээс “Болзошгүй террорист халдлагын үед Улсын бүртгэлийн хэлтсийн байрыг хамгаалах, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эх нотлох баримтыг нүүлгэн шилжүүлэх” санал хүргүүлж Тагнуулын ерөнхий газрын даргаар батлуулж төлөвлөгөөнд тусгалаа.

3. Төв аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 2020 оны 04 сарын 10-ний өдөр хэрэгжүүлсэн “Миний гэр-Аюулгүй орчин” аянд нэгдэж хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор албан хаагчдын гэрийн орчин нөхцлийг үнэллээ. Уг үнэлгээний дагуу албан хаагчид өөрсдийн гэртээ цахилгааны болон ахуйн аюултай эд зүйлсийг шалгаж аюулгүй байдлыг хангалаа.

4. Аймгийн Засаг даргын 2020 оны 02 сарын 18-ны өдрийн А/95 дугаар захирамжаар тус хэлтэст 35,97 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ зохион байгуулан 2020 оны 5-р сард архивын нягтруулсан шүүгээ 20 ширхэг, суудлын автомашин /PRIUS/-ы хамт авч өгсөн.

5. Төв ТВ, Төв аймгийн Жаргалтай ээжүүд групптай хамтран “Хайраар дүүрэн зүрх” аяныг 2020 оны 04 сарын 28-ний өдөр зохион байгуулж эрсдэлт нөхцөлд байгаа айл өрхийн хүүхдүүдэд хүнсний бүтээгдэхүүн, хувцас, ахуйн хэрэглээний материалын нийт **207,000** /хоёр зуун долоон мянга/ төгрөгийн тусламж үзүүлсэн. “Нэг байгууллаг-Нэг хүүхэд” хөдөлгөөний хүрээнд тус хэлтсийн хариуцсан Зуунмод сумын 2-р багт оршин суух Бямбадоржийн Ургамал /хөгжлийн бэрхшээлтэй 10 настай/-ыг 2020 оны 06 сарын 01-ны өдөр хүлээн авч хүүхдийн баярын бэлэг, **30,000** төгрөгийн тусламжийн хамт гардуулсан.

6. 2020 оны 7-р сард болсон үер усны гамшигт өртөн бичиг баримтгүй болсон Зуунмод сумын 2 иргэнд иргэний үнэмлэх, 6 хүүхдэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй дахин олголоо.

7. Төв аймгийн залуус ТББ-тай хамтран 2020 оны 09 дүгээр сард 100,000 төгрөгийн хичээлийн хэрэгсэл зорилгод бүлгийн хүүхдүүдэд хүргүүллээ.

8. Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газраас 450,000 төгрөг, хэлтсийн дотоод нөөцөөс 210,000 төгрөг тус тус гаргаж Сэргэлэн, Жаргалант сумдад улсын бүртгэлийн онлайн сүлжээний гэмтсэн тоног төхөөрөмжийг шинээр авч өгсөн.

9. 2020 оны 10-р сарын 07-нд “Эцсийн өмчлөгчийн бүртгэл-100%” арга хэмжээг зохион байгуулах аяны удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан 27 сумын Засаг даргын тамгын газар, сумдын улсын бүртгэгч нарт хүргүүлж хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хуульд заасан хугацаанд бүртгүүлэх ажлыг зохион байгуулав. Аяны хүрээнд сумдад багийн Засаг дарга нар, сумын төрийн сангийн мэргэжилтэн, татварын улсын байцаагч, улсын бүртгэгч нарыг оролцуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байсан боловч Ковид19 цар тахлын улмаас улс даяар бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэх ажил удааширсан. Аян зарласнаас хойш аймгийн **983** хуулийн этгээд эцсийн өмчлөгчөө бүртгүүлсэн байна.

10. “Монголын Хараагүйчүүдийн төв” ТББ-тай хамтран ажиллаж хараагүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний бүрдүүлэх материалын жагсаалтаар брайл, крилл үсэг хосолсон байдлаар гарын авлага хэвлүүллээ. Ингэснээр эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүндрэл бэрхшээлгүйгээр бүртгэлийн үйлчилгээ авах боломжтой боллоо.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ЭНХБАТ

2020 оны 12 дугаар сарын 15


Улсын бүртгэлийн ерөнхий газрын сургалтын баг 2020 оны 10 дугаар сарын 03-нд хэлтсийн нийт албан хаагчдад бүсийн сургалт зохион байгуулсан.



Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад програмын болон тоног төхөөрөмжийн сургалт зохион байгуулсан.




Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад 2 удаа онлайн сургалт зохион байгуулсан.



Төв ТВ, Төв аймгийн Жаргалтай ээжүүд групптай хамтран “Хайраар дүүрэн зүрх” аяныг 2020 оны 04 сарын 28-ний өдөр зохион байгуулж эрсдэлт нөхцөлд байгаа айл өрхийн хүүхдүүдэд хүнсний бүтээгдэхүүн, хувцас, ахуйн хэрэглээний материалын нийт **207,000** /хоёр зуун долоон мянга/ төгрөгийн тусламж үзүүлсэн.

“Монголын Хараагүйчүүдийн төв” ТББ-тай хамтран ажиллаж хараагүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний бүрдүүлэх материалын жагсаалтаар брайл, крилл үсэг хосолсон байдлаар гарын авлага хэвлүүллээ



Улсын бүртгэлийн үйлчилгээ авч байгаа бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд хүүхдээ саатуулах, хооллох, хуурайлах боломжийг олгох зорилгоор үйлчилгээний зааланд хүүхдийн булан байгуулж хэлтсийн албан хаагчдад зориулан амрах, хувцас солих, үдийн цай уух зориулалттай өрөөг тохижууллаа.



Байгууллагын вэб сайт болон пэйж хуудасны баяжилтууд



ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

2020-12-05 ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН МЭДЭЭЛЭЛ

2020-12-05 QR.119 байршлийн бүртгэл

ВИДЕО МЭДЭЭ


Авлига-Хожихгүй нүүдэл
2020-11-26

Авлигын шилэн бөмбөлөг
2020-11-26

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР ОК ОК

БУСАД МЭДЭЭЛЭЛ →

БУСАД ВИДЕО МЭДЭЭЛЭЛ →



- Монгол улсын хууль
 - УИХ болон ЭГ-ын тогтоол
 - Монгол улсын дээд шүүхийн тогтоол
 - Хууль зүйн сайдын тушаал
 - Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал
 - Журмын төслийн хэлэлцүүлэг

- Үндсэн хууль
 - Улсын бүртгэлийн хуулиуд
 - Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бусад хуулиуд
 - Хүчингүй болсон хуулиуд



ФОТО МЭДЭЭ

Бусад мэдээ >



ВИДЕО МЭДЭЭ

Бусад мэдээ >

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОНООСОН НЭР ЗАХИАЛАХ СИСТЕМ

WWW
LES.BURTGEL.GOV.MN

Ажлын тусгай горимын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд



Төв аймаг дахь Улсын бүртгэл...

6:08

4
159 Views · 31 weeks ago

Page Transparency [See All](#)

Facebook is showing information to help you better understand the purpose of a Page. See actions taken by the people who manage and post content.

Page created - January 19, 2015

Related Pages

- Төв аймаг Мэргэжлийн ...
Sugarkhishig Bambagai likes this Government Organization [Like](#)
- Орхон аймаг дахь Улсы...
Дагваа Дагвадорж likes this Government Organization [Like](#)
- Улсын бүртгэлийн ерөн...
Naran Gerel likes this Government Organization [Like](#)

Add Your Business to Facebook
Showcase your work, create ads and connect with customers or supporters.

[Create Page](#)

Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс
December 4 at 4:57 PM · [View](#)

Иргэн та Улсын бүртгэлийн хэлтсээр үйлчлүүлэхдээ бүртгэлийн QR кодыг заавал уншуулан корона вирусын /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлж хамтдаа тэмцэхийг уриалж байна.

You, Г. Мөнхцэцэг, Enguu Gegee and 3 others
2 Shares

[Like](#) [Comment](#) [Share](#)

Write a comment...

-----000-----

